



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/549

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 228 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААХААГ/20250202133 дугаар бүхий "Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд угаалга, ариутгал халдваргүйжүүлэлтийн тусгай зориулалтын машин" худалдан авах ажлыг "Балобан юү эй эс технологи" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т олгосугай.

2.Ажлын даалгаврыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

